



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА Б.АЗЖАРГАЛ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

Засгийн газрын VIII байр, Олимпийн гудамж 2,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14210
Утас: (976-51) 26 36 95, Факс: (976-11) 32 35 41
Цахим шуудан: letter@moh.gov.mn
Цахим хуудас: www.moh.gov.mn


2025.08.18 № 10/3948
танай -ны № -т

Үнэлгээний тайлан хүргүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан "Журам батлах тухай", Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 дугаар тушаалаар баталсан "Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг тус тус үндэслэн Эрүүл мэндийн сайд аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан 2025 онд хамтран ажиллах гэрээний хавсралтаар батлагдсан Чанарын үзүүлэлтийн эхний хагас жилийн гүйцэтгэлд хийсэн үнэлгээний тайлан, санал, зөвлөмжийг хавсралтаар хүргүүлж байна.

Санал, зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллана уу.

Хавсралт: 13 хуудастай.



Ж.ЧИНБҮРЭН

141250681

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧААС
АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН ХАМТРАН
АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ЧАНАРЫН ҮЗҮҮЛЭЛТИЙН БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ
(2025 оны эхний хагас жилийн байдлаар)**

Нэг. Үнэлгээний үндэслэл ба арга зүй

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны "Журам шинэчлэн батлах тухай" 43 дугаар тогтоолоор, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 дугаар тушаалаар батлагдсан "Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг тус тус үндэслэн Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагч, аймаг, нийслэлийн Засаг дарга нарын 2025 онд хамтран ажиллах гэрээний эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлтэд үнэлгээ хийлээ.

Хоёр. Үнэлгээний зорилго

Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагч, аймаг, нийслэлийн Засаг дарга нарын байгуулсан 2025 онд хамтран ажиллах гэрээний эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлтэд үнэлгээ хийж, гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, удирдлагыг бодит мэдээллээр хангахад оршино.

Гурав. Үнэлгээний дүн

Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагч, аймаг, нийслэлийн Засаг дарга нарын 2025 онд хамтран ажиллах гэрээний эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлтийг үнэлэхдээ урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу гаргаж, үзүүлэлт тус бүрийн хэрэгжилтийг хувиар илэрхийлэн тооцсон болно.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлт

Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагчаас Засаг дарга нартай 2025 онд хамтран ажиллах гэрээний 1 дүгээр хавсралтаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын 23 шалгуур үзүүлэлтийг баталсан байна. Үүнд:

1. Эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгийн 5 үзүүлэлт
2. Дархлаажуулалтын 3 үзүүлэлт
3. Эх, хүүхдийн эрүүл мэндийн 7 үзүүлэлт
4. Халдварт өвчний 2 үзүүлэлт
5. Хүн амын нас баралттай холбоотой 6 үзүүлэлт

2025 оны хагас жилийн байдлаар Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн хэрэгжилтийн явц 51.2 хувь буюу 2.6 оноо байгаа нь "үр дүн хангалтгүй" буюу зорилт шалгуур үзүүлэлт нь зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх, зорилтод чиглэсэн арга хэмжээг сайжруулах шаардлагатайг харуулж байна.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийг урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлэг, товлот дархлаажуулалт, эх, хүүдийн эрүүл мэнд, халдварт өвчин, хүн амын нас баралттай холбоотой үзүүлэлт гэсэн 5 сөрөнхий багц үзүүлэлтийг харьцуулан гаргалаа.

3.1 Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг шинжилгээ, оношилгоо

Улсын хэмжээнд 2025 оны эхний 6 сарын байдлаар хийгдсэн нийт амбулаторийн үзлэгийн 25.4 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.2 нэгж хувиар өссөн байна. Тухайлбал:

- Артерийн гипертензийг эрт илрүүлэх үзлэгт 18 ба түүнээс дээш насны хүн амын 35.7% буюу 774,953 хүн хамрагдсанаас 0.5 хувь буюу 4132 хүнд артерийн гипертензи оношлогдсон;

- Хоёрдугаар хэвшинжийн чихрийн шижин өвчнийг эрт илрүүлэх үзлэгт 35 ба түүнээс дээш насны хүн амын 45.0 хувь буюу 627,406 хүн хамрагдсанаас 0.2 хувь буюу 1090 хүнд хоёрдугаар хэвшинжийн чихрийн шижин оношлогдсон;

- Хөхний хорт хавдрыг эрт илрүүлэх үзлэгт зорилтот насны эмэгтэйчүүдийн 33.7 хувь буюу 293,128 эмэгтэй хамрагдсанаас хавдрын шинэ өвчлөлийн 1 тохиолдол батлагдсан;

- Умайн хүзүүний хорт хавдрын эсийн шинжилгээнд суурилсан илрүүлэх үзлэгт зорилтот насны нийт хүн амын 20.6% буюу 50,751 эмэгтэй хамрагдсанаас умайн хүзүүний хорт хавдрын шинэ өвчлөлийн 2 тохиолдол бүртгэгдсэн байна.


Улс орон даяар хэрэгжиж байгаа эрт илрүүлэх үзлэг, оношилгоонд 2025 оны эхний хагас жилийн байдлаар 1,928,501 хүн буюу зорилтот хүн амын 34.3 хувь хамрагдсан бөгөөд 2024 оны мөн үеэс 494,623 үзлэгээр нэмэгдсэн боловч зорилтот бүлгийн хүн амд эзлэх хувь нь 8.1 нэгж хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Урьдчилан сэргийлэх, халдварт бус өвчнийг эрт илрүүлэх үзлэгийн үзүүлэлтүүд, аймгаар

№	Аймаг/хот	Урьдчилан сэргийлэх үзлэг			Артерийн гипертензи эрт илрүүлэг		Чихрийн шижин хам шинж-2 эрт		Элэгний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэг		Хөхний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэг		Умайн хүзүүний хорт хавдрын эрт	
		Нийт үзлэг	Урьдчилан сэргийлэх үзлэг	Хамрагдсан хувь	Хамрагдсан хүний тоо	Хамрагдсан хувь	Хамрагдсан хүний тоо	Хамрагдсан хувь	Хамрагдсан хүний тоо	Хамрагдсан хувь	Зорилтот насны хамрагдсан хүний тоо	Хамрагдсан хувь	Зорилтот насны хамрагдсан хүний тоо	Хамрагдсан хувь
A	Б	26	27	28	2	3	5	6	8	9	11	12	14	15
1	Архангай	198096	67702	34.2	14562	24.4	15844	42.1	0	0.0	8496	37.8	1483	23.6
2	Баян-Өлгий	252545	55257	21.9	17216	26.4	10355	28.6	1	0.0	8449	37.0	106	1.6
3	Баянхонгор	162813	41822	25.7	17530	31.6	11955	35.0	4135	17.5	2158	10.1	2099	34.6
4	Булган	145264	30102	20.7	11813	29.7	8836	32.9	814	4.3	4735	30.7	1088	26.3
5	Говь-Алтай	181144	42461	23.4	10287	27.8	8797	38.1	5646	34.3	5325	38.3	1225	31.1
6	Говьсүмбэр	68191	10506	15.4	6718	60.2	5667	81.6	733	15.5	2868	66.6	164	13.0
7	Дархан-Уул	363634	105189	28.9	34092	51.6	31362	71.6	20675	69.1	18613	67.9	2948	38.6
8	Дорноговь	245206	58722	23.9	20674	44.9	15349	52.3	11933	59.8	9254	53.5	1239	25.0
9	Дорнод	260497	78026	30.0	19539	37.0	14660	42.4	1923	8.2	10640	51.3	1592	27.3
10	Дундговь	94797	22875	24.1	10574	35.1	9086	46.6	923	6.9	3770	32.8	1143	36.7
11	Завхан	203981	49644	24.3	13085	28.2	9221	31.1	1995	9.3	1236	6.9	755	15.4
12	Орхон	410987	144399	35.1	28285	41.7	25715	57.0	845	2.7	9448	33.5	1726	21.9
13	Өвөрхангай	297266	73545	24.7	21159	28.7	17416	37.8	8623	27.1	11374	40.3	3146	40.0
14	Өмнөговь	221863	51875	23.4	7396	14.9	7227	23.2	7294	35.2	3024	16.7	563	10.5
15	Сүхбаатар	143834	35417	24.6	17339	41.6	13481	50.3	197	1.1	6372	39.8	1938	42.8
16	Сэлэнгэ	287691	84615	29.4	23268	33.8	22328	49.3	20199	63.3	917	3.5	895	12.4
17	Төв	216038	82710	38.3	28108	47.0	21220	52.3	798	2.8	9646	42.9	1467	24.4
18	Увс	205009	48236	23.5	12185	23.5	10027	33.2	545	2.5	7056	37.8	1086	20.0
19	Ховд	253781	45834	18.1	12896	23.1	10124	30.9	248	1.1	6625	32.9	842	14.6
20	Хөвсгөл	396479	171154	43.2	30926	35.3	23386	42.5	13235	34.5	13590	40.3	3262	34.4
21	Хэнтий	200274	45337	22.6	15192	30.0	13801	42.7	2813	12.4	6187	32.5	872	16.4
22	Аймгийн дундаж	4809390	1345428	28.0	372844	33.4	305857	43.3	103575	21.1	149783	35.2	29639	24.7
23	Улаанбаатар	7591483	1800326	23.7	402109	38.2	321549	46.9	78688	17.5	143345	32.3	21112	16.7
24	Улсын дундаж	12400873	3145754	25.4	774953	35.7	627406	45.0	182263	19.4	293128	33.7	50751	20.6


Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэгт хамрагдсан 18 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Увс, Ховд, Хэнтий аймагт аймгийн дунджаас бага, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Дундговь, Орхон, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Хөвсгөл аймаг болон Улаанбаатар хотод дунджаас их байна.

График 1. Артерийн гипертензийн эрт илрүүлэгт хамрагдсан хүн амын эзлэх хувь, аймгаар




Хоёрдугаар хэвшинжийн чихрийн шижин өвчний эрт илрүүлэгт хамрагдсан хүн амын эзлэх хувь Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Дорнод, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймагт аймгийн дунджаас бага, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Орхон, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв аймаг болон Улаанбаатар хотод дунджаас их байна.

График 2. Хоёрдугаар хэвшинжийн чихрийн шижин өвчний эрт илрүүлэгт хамрагдсан хүн амын эзлэх хувь, аймгаар




Хөхний хорт хавдрын эрт илрүүлэгт хамрагдсан хүн амын эзлэх хувь Баянхонгор, Булган, Дундговь, Завхан, Орхон, Өмнөговь, Сэлэнгэ, Ховд, Хэнтий аймаг болон Улаанбаатар хотод аймгийн дунджаас бага, Архангай, Баян-Өлгий, Говьсүмбэр, Говь-Алтай, Дархан-Уул, Дорнод, Дорноговь, Сүхбаатар, Өвөрхангай, Увс, Төв, Хөвсгөл аймагт дунджаас их байна.

График 3. Хөхний хорт хавдрын эрт илрүүлэгт хамрагдсан хүн амын эзлэх хувь, аймгаар



Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэгт хамрагдсан хүн амын эзлэх хувь Архангай, Баян-Өлгий, Говьсүмбэр, Завхан, Өмнөговь, Орхон, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хэнтий аймаг болон Улаанбаатар хотод аймгийн дунджаас бага, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Дархан-Уул, Дорнод, Дорноговь, Дундговь, Сүхбаатар, Өвөрхангай, Хөвсгөл аймагт дунджаас их байна.

График 4. Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэгт хамрагдсан хүн амын эзлэх хувь, аймгаар




3.2 Товлолт дархлаажуулалт

Улсын хэмжээнд 2025 оны эхний 6 сарын байдлаар товлот дархлаажуулалт 95 хувиас дээш үзүүлэлттэй байна.

Дархлаажуулалтын хамралтын хувь дараах аймгуудад өмнөх оны мөн үеэс буурчээ. Үүнд:

- В вируст гепатитын эсрэг дархлаажуулалтын хамралтын хувь Архангай, Дархан, Дорноговь, Дундговь, Сүхбаатар, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймаг болон Улаанбаатарт,
- Тавт (сахуу, хөхүүл ханиад, татран, В гепатит, хемофилүсинфлюенза) вакцины хамралтын хувь Архангай, Баян-Өлгий, Говь-Алтай, Дархан-Уул, Дорноговь, Өвөрхангай, Өмнөговь Төв, Увс, Ховд, Хэнтий аймаг болон Улаанбаатарт,
- Улаанбурхан-гахай хавдар-улаануудын (УГУ) эсрэг сэргийлэх тарилгын хамралтын хувь Баян-Өлгий, Говьсүмбэр, Дархан, Завхан, Өмнөговь, Хөвсгөл, Хэнтий аймагт.

График 5. Төвлөлт дархлаажуулалтын хамралтын хувь, аймгаар




3.2 Эх, хүүхдийн эрүүл мэндтэй холбоотой үзүүлэлтүүд

1. Жирэмсний хяналт

Улсын хэмжээнд 2025 оны эхний 6 сарын байдлаар жирэмсний хяналтад шинээр 29,977 эмэгтэй хамрагдсан ба 93.5 хувь нь эхний 3 сартайд, 5.8 хувь нь 4-6 сартайд, 0.7 хувь нь 7 ба түүнээс дээш сартайд хяналтад орсон байна.

График 6. Жирэмсний хяналт, хувиар



Жирэмсний хяналт Архангай, Баянхонгор, Булган, Дорноговь, Завхан, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Хөвсгөл аймаг болон Улаанбаатар хотод улсын дунджаас доогуур үзүүлэлттэй байна. Мөн Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Дархан, Орхон, Сэлэнгэ, Увс аймгууд суурь түвшингээс буурсан байна.

2. Эхийн эндэгдэл

Улсын хэмжээнд 2025 оны эхний 6 сарын байдлаар эхийн эндэгдлийн 9 тохиолдол бүртгэгдэж, 100,000 амьд төрөлтөд 33.3 ногдож байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 5 тохиолдол буюу 100,000 амьд төрөлтөд 19.4-өөр өссөн байна.


Эхийн эндэгдлийн тохиолдол Баянхонгор, Дархан-Уул, Дорноговь, Сэлэнгэ, Увс аймаг болон Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна. Сэлэнгэ аймагт сүүлийн 2 жилийн хугацаанд дараалан эхийн эндэгдэл өссөн үзүүлэлттэй байна.

3. Нялхсын эндэгдлийн түвшин

Улсын хэмжээнд 2025 оны эхний 6 сарын байдлаар нялхсын эндэгдлийн 378 тохиолдол бүртгэгдэж, 1,000 амьд төрөлтөд 14.0 ногдож байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 23 тохиолдол буюу 1,000 амьд төрөлтөд 1.7-оор өссөн үзүүлэлттэй байна. Нялхсын эндэгдлийн 63.8 хувийг нярайн эндэгдэл эзэлж байгаа ба 1,000 амьд төрөлтөд ногдох нярайн эндэгдэл, 8.9 байна. Нярайн эндэгдлийн нийт 241 тохиолдлын 179 буюу 74.3 хувь нь эрт үеийн эндэгдэл, 62 буюу 25.7 хувийг хожуу үеийн эндэгдэл тус тус эзэлж байна.

2025 оны эхний 6 сарын байдлаар 1,000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийг аймгуудаар харьцуулбал: Увс (27.1), Өвөрхангай (21.9), Булган (21.5), Өмнөговь (20.0), Баян-Өлгий (19.3), Хөвсгөл (16.4), Төв (16.1) аймаг болон Улаанбаатар хотод (14.7) улсын дундаж үзүүлэлтээс 0.7-13.1-ээр өндөр байна.

Зураг 1. Нялхсын эндэгдэл (1,000 амьд төрөлтөд, аймгаар)



4. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл

Улсын хэмжээнд 2025 оны эхний 6 сарын байдлаар тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 451 тохиолдол бүртгэгдэж, 1,000 амьд төрөлтөд 16.7 ногдож байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8 тохиолдлоор буюу 1,000 амьд төрөлтөд 1.3-аар өссөн үзүүлэлттэй байна. Нийт тохиолдлын 19.9 хувь нь эмнэлгээс гадуур, 80.1 хувь нь эмнэлэгт нас барсан ба үүнээс хоног болоогүй нас баралт 25.1 хувийг эзэлж байна.

Аймгуудаар харьцуулбал: 1,000 амьд төрөлтөд ногдох тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл Булган (34.3), Увс (32.9), Төв (32.2), Өвөрхангай (25.5), Баян-Өлгий (21.7), Хөвсгөл (20.7), Сэлэнгэ (17.6) аймагт улсын дундаж үзүүлэлтээс 0.9-17.6-аар өндөр байна.

Зураг 2. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл (1,000 амьд төрөлтөд, аймгаар)



Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл Хөвсгөл аймагт улсын дунджаас өндөр ч гэсэн өмнөх онтой харьцуулахад эндэгдэл буурсан үзүүлэлттэй байна. Мөн Говьсүмбэр аймаг тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл гаргаагүй байна.

5. Амьгүй төрөлтийн түвшин

2025 оны эхний 6 сарын байдлаар улсын хэмжээнд амьгүй төрөлтийн 121 тохиолдол бүртгэгдэж, 1,000 төрөлтөд 4.5 ногдож байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 31 тохиолдол буюу 0.7-оор буурсан үзүүлэлттэй байна. Амьгүй төрөлт Говьсүмбэр (14.1), Архангай (11.2), Дорнод (7.8), Дундговь (7.1), Ховд (6.1), Орхон (5.2), Улаанбаатар (5.1), Говь-Алтай (4.8), Дорноговь (4.7), Сүхбаатар (4.7) аймаг, Улаанбаатар (5.1) хотод улсын дунджаас 0.2-9.6-аар өндөр байна.

3.4 Халдварт өвчний үзүүлэлт

Улсын хэмжээнд 2025 оны эхний 6 сарын байдлаар халдварт өвчний 32,260 тохиолдол бүртгэгдэж, 10,000 хүн амд 91.0 ногдож байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 10,241 тохиолдлоор буюу 10,000 хүн амд ногдох өвчлөл 28.2-оор нэмэгдсэн байна. 10,000 хүн амд ногдох халдварт өвчний үзүүлэлт Дорнод (132.1), Өмнөговь (125.8) аймгууд болон Улаанбаатар (122.6) хотод улсын дундаж үзүүлэлтээс 31.5-41.1-ээр их байна.

Халдварт өвчний зарим тохиолдлыг авч үзвэл 2025 оны эхний 6 сарын байдлаар 1148 сүрьеэгийн өвчлөл бүртгэгдэж, 10,000 хүн амд 3.2 байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 64 тохиолдлоор буюу 0.3-аар буурсан, вируст гепатитын өвчлөлийн 123 тохиолдол бүртгэгдэж, 10,000 хүн амд 0.3 байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 20 тохиолдлоор буурсан байна.

Улсын хэмжээнд 2025 оны эхний 6 сарын байдлаар халдварт өвчний нас баралтын 38 тохиолдол бүртгэгдсэнээс сүрьеэ (19), вируст гепатит (3) тус тус бүртгэгдсэн байна.

Хүснэгт 2. Халдварт өвчний үзүүлэлтүүд, аймгаар

№	Аймаг хот	Нийт халдварт өвчин, эхний 6 сараар						Нас баралт
		Өвчлөл			10 000 хүнд			
		2024	2025	5 жилийн дундаж	2024	2025	5 жилийн дундаж	
1	Архангай	394	409	1501	42.7	44.7	161.1	1
2	Баян-Өлгий	426	330	698	36.5	27.9	60.6	1
3	Баянхонгор	823	536	2210	93.3	60.9	249.8	1
4	Булган	246	154	812	40.6	25.5	132.6	0
5	Говь-Алтай	367	233	1708	64.7	41.2	298.6	0
6	Говьсүмбэр	130	153	633	72.1	84.3	351.2	0
7	Дархан-Уул	876	636	1316	80.2	57.5	121.4	0
8	Дорноговь	656	607	1991	91.7	84.2	279.4	0
9	Дорнод	1387	1118	2347	165.0	132.1	279.8	2
10	Дундговь	183	403	920	39.7	87.8	198.3	0
11	Завхан	202	428	1657	28.4	60.5	230.7	0
12	Орхон	406	434	1730	36.8	38.8	158.4	2
13	Өвөрхангай	460	621	1591	40.1	54.3	138.3	1
14	Өмнөговь	1069	973	3104	142.2	125.8	422.5	1
15	Сүхбаатар	414	552	1296	63.0	83.9	198.6	0
16	Сэлэнгэ	270	310	1819	25.3	29.2	169.6	1
17	Төв	724	799	2268	79.2	87.3	245.8	4
18	Увс	322	299	1253	38.4	35.2	149.1	1
19	Ховд	375	416	1731	41.0	45.0	189.9	0
20	Хөвсгөл	740	741	1574	54.1	54.3	115.1	1
21	Хэнтий	188	439	1186	23.8	55.4	150.2	0
22	Аймгийн дүн	10658	10591	33347	60.2	59.6	188.6	16
23	Улаанбаатар	11361	21669	58575	65.5	122.6	347.9	22
24	Улсын дүн	22019	32260	91922	62.8	91.0	266.0	38

3.5 Хүн амын нас баралттай холбоотой үзүүлэлтүүд

Хүн амын нас баралтын зонхилох шалтгаан болсон дараах үзүүлэлтүүд өмнөх оны мөн үеэс буурчээ. Үүнд:

Зүрх судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтын 2806 тохиолдол бүртгэгдэж, 10,000 хүн амд 8.2 ногдож байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.1-ээр;

Хорт хавдраас шалтгаалсан нас баралтын 2119 тохиолдол бүртгэгдэж, 10,000 хүн амд 6.2 ногдож байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.4-өөр;

Санамсаргүй хордох, хорт бодист өртсөнөөс шалтгаалсан нас баралтын 483 тохиолдол бүртгэгдэж, 10,000 хүн амд 1.4 ногдож байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.1-ээр;

Хүүхдийн зам тээврийн ослын шалтгаант нас баралтын 19 тохиолдол бүртгэгдэж 10,000 хүүхдэд 0.2 ногдож байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 0.1-ээр.

Гэвч амиа хорлож нас барсан 283 тохиолдол бүртгэгдэж, 10,000 хүн амд 0.8 ногдож байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 0.1-ээр нэмэгдсэн байна. 10,000 хүн амд ногдох амиа хорлож нас барсан тохиолдол Дорноговь (2.1), Хөвсгөл (1.6), Архангай (1.4), Дундговь (1.3), Баянхонгор (1.1), Сүхбаатар (1.1), Сэлэнгэ (1.1), Төв (1.1), Увс (1.1), Булган (1.0), Өвөрхангай (1.0), Хэнтий (0.9) аймагт улсын дундаж үзүүлэлтээс 0.1-1.3-аар их байна.

Мөн 0-5 насны хүүхдийн түлэгдэлтийн 1848 тохиолдол бүртгэгдэж, 10,000 хүүхдэд 54.7 байгаа нь өмнөх оны мөн үеэс 169 тохиолдол буюу 1.7-оор буурсан байна.


Хүснэгт 3. Нас баралт 10,000 хүн амд, аймгаар

№	Аймаг, хот	Санамсаргүй хордох, хорт бодист өртөх		Амиа хорлолт		Зүрх судас		Хорт хавдар		0-14 насны зам тээврийн осол	
1	Архангай	11	1.2	13	1.4	106	11.3	61	6.5	1	0.4
2	Баян-Өлгий	0	0.0	4	0.4	82	7.4	56	5.1	0	0.0
3	Баянхонгор	1	0.1	10	1.1	69	7.8	54	6.1	0	0.0
4	Булган	10	1.7	6	1.0	71	11.8	53	8.8	0	0.0
5	Говь-Алтай	2	0.4	4	0.7	61	10.7	34	6.0	2	1.2
6	Говь-Сүмбэр	0	0.0	0	0.0	16	8.8	9	4.9	0	0.0
7	Дархан-Уул	4	0.4	3	0.3	95	9.1	84	8.1	0	0.0
8	Дорноговь	12	1.7	15	2.1	43	6.0	44	6.1	0	0.0
9	Дорнод	2	0.2	3	0.4	58	6.9	61	7.2	0	0.0
10	Дундговь	2	0.4	6	1.3	58	12.6	30	6.5	0	0.0
11	Завхан	3	0.4	4	0.6	69	9.6	36	5.0	0	0.0
12	Орхон	8	0.8	1	0.1	88	8.3	72	6.8	0	0.0
13	Өвөрхангай	8	0.7	11	1.0	103	8.9	52	4.5	1	0.3
14	Өмнөговь	3	0.4	5	0.6	52	6.7	26	3.4	2	0.8
15	Сүхбаатар	1	0.2	7	1.1	34	5.1	55	8.3	1	0.5
16	Сэлэнгэ	12	1.1	12	1.1	105	9.9	81	7.7	2	0.6
17	Төв	5	0.5	10	1.1	76	8.3	57	6.2	5	1.8
18	Увс	3	0.4	9	1.1	96	11.3	67	7.9	1	0.4
19	Ховд	0	0.0	4	0.4	46	5.1	48	5.3	0	0.0
20	Хөвсгөл	8	0.6	22	1.6	144	10.5	76	5.5	0	0.0
21	Хэнтий	5	0.6	7	0.9	52	6.6	67	8.5	0	0.0
22	Аймгийн дүн	100	0.6	156	0.9	1524	8.7	1123	6.4	15	0.3
23	Улаанбаатар	383	2.3	127	0.8	1282	7.7	996	6.0	4	0.1
24	Улсын дүн	483	1.4	283	0.8	2806	8.2	2119	6.2	19	0.2

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн нэгдсэн үнэлгээ

Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагчаас аймаг, нийслэлийн Засаг дарга нартай 2025 онд хамтран ажиллах гэрээний эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн дундаж гүйцэтгэл **51.2** хувь буюу 2.6 оноо байгаа нь “үр дүн хангалтгүй” гэж үнэлэгдсэн ба үзүүлэлтийг харуулбал:

График 7. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлт, эхний 6 сараар, аймгаар



Дөрөв. Дүгнэлт

Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагчаас аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан 2025 онд хамтран ажиллах гэрээнд тусгагдсан Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлт эхний 6 сарын байдлаар 51.2 хувь буюу “хангалтгүй” гэж үнэлэгдэв. Өмнөх оны мөн үед 64.2 хувь буюу “эрчимжүүлэх шаардлагатай” гэж үнэлэгдсэн ба 2025 оны хөгжсөн жилийн байдлаар 13.0 хувиар буурсан байна.

1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын ихэнх шалгуур үзүүлэлт зорилтот түвшинд хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх, зорилтод чиглэсэн арга хэмжээг сайжруулах шаардлагатай байна.

2. Урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлэг, товлोलт дархлаажуулалт, эх, хүүхдийн эрүүл мэндтэй холбоотой зарим үзүүлэлт зорилтот түвшинд хүрээгүй байна.

3. Эхийн эндэгдэл, нярай болон нялхсын эндэгдэл, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл өмнөх оны мөн үеэс өссөн байгаа нь жирэмсний хяналт болон хүүхдийн гэрийн эргэлтийн тусламж, үйлчилгээг сайжруулах шаардлагатайг харуулж байна.

4. Амиа хорлолт өмнөх оны мөн үеэс өссөн бөгөөд Дорноговь, Хөвсгөл, Архангай, Дундговь, Баянхонгор, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Увс, Булган, Өвөрхангай, Хэнтий аймагт улсын дунджаас их, Улаанбаатар хотод улсын дундажтай ижил түвшинд байна.

Тав. Зөвлөмж

1. Удирдлага, зохион байгуулалтыг бэхжүүлэх

- Аймаг, нийслэлийн түвшинд удирдлагын хариуцлагыг нэмэгдүүлэх, чанарын үзүүлэлтийг сайжруулах зорилтот арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Хамтын гэрээний хэрэгжилтийн явцад улирал тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, арга хэмжээ авах.

2. Хүн амын эрүүл мэндийг дэмжих, хамгаалах тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх:

- Хүн амын нас, эрүүл мэндийн байдал, эрсдэлтэй уялдуулан хэрэгжүүлж буй эрт, илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгийг үр дүнтэй, хүртээмжтэй зохион байгуулах, өвчлөл илэрсэн тохиолдлыг эмнэлгийн хяналтад авч эрүүлжүүлсэн байдалд хяналт тавьж, үр дүнг тооцох;
- Эхийн болон хүүхдийн эндэгдлийг бууруулах, жирэмсний хяналтын эхний 3 сарын хамрагдалтыг нэмэгдүүлэх, эрсдэлтэй жирэмслэлтийг эрт илрүүлэх, хяналт сайжруулах, тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх;
- Зүрх судасны болон хорт хавдрын шалтгаант нас баралт, осол гэмтэл, гадны шалтгаант нас баралт, амиа хорлолт зэргийг бууруулахад олон нийтэд чиглэсэн, амьдарлын хэв маягт суурилсан урьдчилан сэргийлэх хөтөлбөр, сургалт, сурталчилгаа, сэтгэл зүйн зөвлөгөө, дэмжлэгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

ЗАСАГ ДАРГА НАРЫН ГЭРЭЭНИЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

№	Үзүүлэлт	АР	БӨ	БХ	БУ	ГА	ГС	ДА	ДГ	ДО	ДУ	ЗА	ОР	ӨВ	ӨМ	СҮ	СЭ	ТӨ	УВ	ХО	ХӨ	ХЭ	УБ	Дундаж
1	Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгэнд хамрагдсан 18 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь	100	0	20.8	0	0	100	0	100	100	100	100	0	0	0	100	0	100	62.3	100	60.3	0	100	52.0
2	Чихрийн шижин хэв шинж-2 өвчний эрт илрүүлгэнд хамрагдсан 40 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь	100	0	77.4	0	0	100	0	100	24.6	100	100	100	0	0	100	0	100	13.9	100	100	0	0	50.7
3	Хөхний өмөнгийн эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан 30 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн тоо	0	0	0	0	0	100	100	100	100	100	100	0	0	0	100	0	100	100	10	43.3	0	100	47.9
4	Умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлгэнд хамрагдсан 30 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн эзлэх хувь	100	0	0	0	100	0	0	100	0	100	100	0	100	0	100	36.7	100	42.6	0	0	0	0	40.0
5	Урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь	85.7	0	0	0	0	0	38.5	22	53.3	100	32	45	0	0	100	37.5	2.7	20.7	44.7	0	0	100	31.0
6	В вируст гепатитийн эсрэг сэргийлэх тарилгын 24 цагийн хамралтын хувь	0	100	0	70	100	100	0	0	0	0	100	100	0	100	0	70	100	0	0	0	0	0	38.2
7	Тавт (сахуу, хөхүүл ханиад, татран, В гепатит, хемофилосинфлюенза) сэргийлэх тарилгын хамралтын хувь /3-р тун/	0	0	100	11.8	0	100	0	100	0	68.8	57	70	0	0	97.6	100	0	0	0	100	0	0	36.6
8	Улаанбурхан-гахайн хавдар-улаануудын (УГУ) эсрэг сэргийлэх тарилгын хамралтын хувь /2-р тун/	100	0	100	100	100	0	0	100	100	100	0	100	100	0	100	100	100	100	28.6	0	0	100	64.9
9	Эхийн эндэгдлийн түвшин (100 000 амьд төрөлт тутамд)	100	100	0	100	100	100	0	0	100	100	100	100	100	100	100	0	100	0	100	100	100	0	72.7
10	Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт тутамд)	100	0	100	0	100	100	0	100	0	0	100	0	0	0	0	50	97.7	0	0	0	100	0	38.5
11	Нярайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт тутамд)	0	39.5	0	0	0	100	0	100	0	100	100	0	0	0	0	50	100	0	100	0	100	0	35.9
12	5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт тутамд)	100	0	100	0	100	100	0	100	100	0	100	0	0	0	0	0	0	0	0	77.3	100	0	39.9
13	Амьгүй төрөлтийн түвшин (1000 төрөлт тутамд)	0	100	100	100	0	0	100	0	0	0	100	0	100	0	0	84.2	0	100	0	100	100	100	49.3
14	Жирэмсний эхний 3 сард хяналтад орсон эхийн эзлэх хувь	0	0	0	0	0	100	0	100	0	80	100	0	100	100	50	0	100	0	100	100	100	100	51.4
15	Өсвөр насны 1000 эмэгтэйд ногдох төрөлтийн түвшин	100	100	0	0	0	100	0	100	100	100	100	0	100	100	100	100	0	100	0	100	0	100	63.6
16	Сүрьеэгийн өвчлөлийн түвшин, 10 000 хүн амд	0	0	0	100	100	0	100	0	0	100	100	100	100	100	0	100	0	0	100	0	100	100	54.5
17	Вируст гепатитын өвчлөлийн түвшин, 10 000 хүн амд	100	100	0	100	100	100	0	100	100	100	100	70	0	0	100	100	0	0	100	100	100	0	62.3
18	Зүрх судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтын түвшин, 10 000 хүн амд	0	100	100	0	0	0	0	0	100	11.3	0	100	100	100	100	0	100	0	100	100	100	0	50.5
19	Хорт хавдраас шалтгаалсан нас баралтын түвшин, 10 000 хүн амд	0	0	0	0	100	100	0	100	100	0	100	100	100	100	0	0	100	100	100	100	0	100	59.1
20	Амиа хорлож нас барсан тохиолдлын түвшин, 10 000 хүн амд	0	0	100	16	100	100	0	0	100	0	100	10	0	100	0	0	0	100	0	100	100	0	42.1
21	Санамсаргүй хордох, хорт бодист өртсөнөөс шалтгаалсан нас баралтын түвшин, 10 000 хүн амд /Х40-Х49/	0	100	100	0	100	100	100	0	100	0	0	100	100	100	100	0	100	0	100	100	100	100	68.2
22	0-5 насны хүүхдийн түлэгдэлтийн түвшин, (10 000 хуульдэд, T20-T32)	100	100	100	100	100	73.6	100	0	0	0	100	0	0	100	45	0	100	100	100	0	100	0	59.9
23	Хүүхдийн зам тээврийн ослын шалтгаант нас баралтын түвшин, (10 000 хуульдэд, V00-V99)	0	100	100	100	4.7	100	100	100	100	100	100	100	0	100	0	0	0	100	100	100	100	13	69.0
	Дундаж хувь	47.2	40.8	47.7	34.7	52.4	72.8	27.8	61.8	55.6	59.1	82.1	47.6	43.5	47.8	56.2	36.0	60.9	40.8	51.4	60.0	56.5	44.0	51.2
	Оноо	2.4	2.0	2.4	1.7	2.6	3.6	1.4	3.1	2.8	3.0	4.1	2.4	2.2	2.4	2.8	1.8	3.0	2.0	2.6	3.0	2.8	2.2	2.6